

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨМА-2022/7/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГА Э.МӨНХБАЯР ТАНАА

2022.03.24 № 277

танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мандал-Овоо сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал-Овоо сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Э.МӨНХБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-03-24 №277с

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	827.4	1,162.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,535.1	9,777.9
	Нийт хөрөнгийн дүн	10,362.5	10,940.1
	Нийт өр төлбөрийн дүн	2,046.8	2,019.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,315.7	8,920.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,362.5	10,940.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	7,366.7	5,385.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	5,332.1	4,557.3
	Үйл ажиллагааны үр дүн	2,034.5	827.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	201.4	239.9
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,833.2	588.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,681.6	8,332.2
	Тайлант оны үр дүн	588.1	588.1
	Эцсийн үлдэгдэл	4,269.6	8,920.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	5,238.3	4,611.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,840.8	4,162.7
	Үйл ажиллагааны ЦМГ	397.6	448.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	157.7	248.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	239.9	200.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	114.4	354.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	354.3	554.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,126.0	2,025.9
	Урсгал зардал	1,905.6	1,818.3
	Хөрөнгийн зардал	220.4	207.6
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,126.0	2,000.3
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	757.4	699.0
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,066.1	1,049.9
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16.1	11.8
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	0.3
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66.0	68.9
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	220.4	170.4

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал-овоо сумын засаг дарга нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Хүний хөгжлийг дэмжсэн улс орон нутгийн бодлого зорилтыг хэрэгжүүлж, нийгмийн салбаруудыг нэгдсэн

удирдлагаар ханган, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих ая тухтай орчин нөхцөлийг хангах" гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал,
- "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- нөөц сангийн 65.9 сая төгрөгийн зарцуулалт хийхдээ Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээгүй,
- нөөц сангийн хөрөнгөөс 0,8 сая төгрөгийг зарцуулалтыг хүчингүй болсон Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалыг үндэслэн шийдвэр гарган зарцуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Засаг даргын нөөц сангаас урсгал засварын зардалд 0,8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2,0 сая төгрөг нийт 3,4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан
- Засаг даргын нөөц сангаас 0,5 сая төгрөгийг байгууллага, иргэдээс ирсэн хүсэлтгүй зарцуулсан байна.
- Засаг даргын нөөц сангаас уралдаан тэмцээн зохион байгуулах зардалд 8,5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Мандал-овоо сумын засаг даргын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал-овоо сумын засаг дарга нь

- Шилэн дансны нэгдсэн системд 150 мэдээлэл байршуулахаас 29 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан
- хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий 14 мэдээллийг байршуулаагүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

- Аудитаар нийт 90,6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 11,4 сая төгрөгийн алдааг залруулж, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Засаг даргын нөөц сангаас уралдаан тэмцээн зохион байгуулах зардалд 8,5 сая төгрөгийг зарцуулсан, 65.9 сая төгрөгийн зарцуулалт хийхдээ Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээгүй, нөөц сангийн хөрөнгөөс 0,8 сая төгрөгийг зарцуулалтыг хүчингүй болсон Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалыг үндэслэн шийдвэр гарган зарцуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан, нөөц сангаас урсгал засварын зардалд 0,8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2,0 сая төгрөг нийт 3,4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, нөөц сангаас 0,5 сая төгрөгийг байгууллага, иргэдээс ирсэн хүсэлтгүй зарцуулсан байна.

Өгсөн албан шаардлага:

Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллах

2.Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн системд 150 мэдээлэл байршуулахаас 29 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий 14 мэдээллийг байршуулаагүй байна.

Өгсөн албан шаардлага:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.3.6 "хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл"-ыг мэдээлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

4.1 Зөвлөмж

1.Илрүүлэлт:

Засаг даргын Нөөц сангийн хөрөнгөөс 0,8 сая төгрөгийг зарцуулалтыг хүчингүй болсон Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалыг үндэслэн шийдвэр гарган зарцуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан, нөөц сангаас 0,5 сая төгрөгийг байгууллага, иргэдээс ирсэн хүсэлтгүй зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал " Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллах

Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ										
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ	8	90,6	5	11,5	0	0	1	77,7	2	1,4
5	ТЕЗ										
	Дүн	8	90,6	5	11,5	0	0	1	77,7	2	1,4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ										
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ	2	0	0	0	0	0	1	0	0	0
5	ТЕЗ										
	Дүн	2	0	0	0	0	0	1	0	0	0
	НИЙТ ДҮН	10	90,6	5	11,5	0	0	2	77,7	2	1,4